БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2019 оны 05 дугаар сарын 31 өдөр

Дугаар 720/2019

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: 976-11-320338

Объектын байршил, нэр:	Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 4-р багийн нутаг дэвсгэрт баригдах “240 хүний суудалтай соёлын төвийн барилга”-ын холболтын ажлын зураг төсөл, төсөв **Шифр: ОСИБ-12/3-2018**
Хүчин чадал:	Барилга нь тэнхлэгээрээ 27.0 м х 27.0 м хэмжээтэй, зоорьгүй, 2 давхар /240 суудал/
Захиалагч:	Хөвсгөл аймгийн Арбулаг ЗДТГ
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр	“БАББ” ХХК
Регистрийн дугаар:	РД: 4124979
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2022.12.14
Ажилбарын төрөл:	1.2.1, 1.2.6 заалтын дагуу
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	
Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх, олгосон захирамж, дугаар огноо:	Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Засаг даргын 2019.01.03-ны өдрийн А/02 тоот захирамж
Архитектур төлөвлөлтийн даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Хөвсгөл аймгийн Ерөнхий архитекторын 2019.04.17-ны өдөр баталсан АТД-2019/18 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Засаг даргын 2019.01.20-ны өдөр баталсан 01/2019 дугаартай зураг төсөл боловсруулах даалгавар
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Засаг дарга, “БАББ” ХХК-ийн захирал нарын хооронд 2019.01.20-ны өдөр байгуулсан 01/2019 дугаартай зураг төсөл боловсруулах гэрээ

Техникийн нөхцөлүүд:

Техникийн нөхцөл	Олгосон байгууллага	Дугаар, огноо:	Хүчинтэй байх хугацаа:
Дулаан хангамж:	-	Өөрийн эх үүсвэрээс	
Ус хангамж, ариутгах татуурга:			
Цахилгаан хангамж:	“Хөвсгөл-Эрчим хүч” ХХК	№ 15/2019 2019.02.25	1 жил
Холбоо, дохиолол:	“МХС” ХХК Хөвсгөл салбар	№ ТН-2019 2019.01.21	1 жил

Зөвшөөрөлцсөн байгууллагууд:	
Хөвсгөл аймгийн Ерөнхий архитектор	Г.Бадамсэрээжид
Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах	Л.Бямбасүрэн

Нийт: 1 - 9

улсын хяналтын байцаагч		
"Хөвсгөл-Эрчим хүч" ХХК-ийн Ерөнхий инженер		Д.Отгонбаяр
"МХС" ХХК-ийн Хөвсгөл аймгийн газрын Ерөнхий инженер		Н.Ширнэндорж
Зураг төслийн бүрэлдэхүүн:		
Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр	Шалгасан экспертийн нэр
Барилга архитектур:	"БАББ" ХХК	А.Дагвасамбуу
Барилга бүтээц:	"БАББ" ХХК	Ч.Тунгалаг
Дулаан хангамж:	"Конар" ХХК	Ц.Жалцав
Гадна, дотор ус хангамж, ариутгах татуурга:	"Конар" ХХК	М.Эрдэнэцэцэг
Цахилгаан хангамж:	"Арбэл-Алтай" ХХК	Б.Ванчигмаа
Гадна, дотор холбоо, дохиолол:	"Арбэл-Алтай" ХХК	Ж.Өлзийбаяр
Барилгын төсөв:	"БАББ" ХХК	Т.Норовжав
Инженер геологи:	"Инженер геодези" ХХК /Архив № 18/150/	Дүгнэлт баталгаажсан О.Балдорж
Ерөнхий дүгнэлт: /Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолын дагуу/		
Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдлийн болон техник-эдийн засгийн үзүүлэлт, зураг төслийн үндсэн төлөвлөлт, техникийн шийдлийн талаар тусгасан товч тодорхойлолт :	**Барилга байгууламжийн ерөнхий өгөгдөл:** Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 4-р багийн нутаг дэвсгэрт баригдах "240 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын холболтын ажлын зураг төслийг аймгийн Ерөнхий архитекторын баталсан АТД-2019/18 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг үндэслэн сумын Засаг даргын А/02 тоот захирамжаар олгосон 0.072 га талбайд байршуулахаар төлөвлөж, боловсруулсан байна. Тус холболтын ажлын зураг төсөл нь 2014.04.30-ны өдрийн 333/2014 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан байна. **Барилгын буурь хөрсний үзүүлэлт:** Барилгын талбайн хөрсний инженер геологийн судалгааны дүгнэлтийг "Инженер геодези" ХХК / Архив № 18/150 тоот/-д боловсруулсан ба инженер геологийн судалгааны дүгнэлтээр инженер геологийн хүнд нөхцөлтэй, бор шаргал өнгөтэй, дээд ба орчин үеийн дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, олон жилийн цэвдэг байдалтай, хайрга агуулсан шавранцар ул хөрстэй гэж тодорхойлсон байна. Газар хөдлөлийн **9** баллын бүсэд хамрагдаж байна. Цэвдэг хөрсний дулаан-физикийн үзүүлэлт: Дулаан дамжуулалтын коефициент: Гэсгэлэн нөхцөлд: λ_{th}=1.35 ккал/м.цаг ^{0}C, Хөлдүү нөхцөлд: λ_f=1.55 ккал/м.цаг ^{0}C, Дулаан багтаамж: Гэсгэлэн нөхцөлд: C_{th}=755 ккал/см^3 ^{0}C, Хөлдүү нөхцөлд: C_f=575 ккал/см^3 ^{0}C, Улирлын хөлдөлтийн норматив гүн 1.5 м **Байгаль цаг уурын өгөгдөл:** Гадна агаарын температур -40°C Цасны ачаалал 50 кг/м^2	

	Салхины дундаж хурд 35 кг/м^2 **Барилга байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:** Барилгын гол орцны хэсэгт "Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага" /БД 31-101-04/, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчин шаардлагад нийцсэн зураг төсөл зохих дүрэм" /БД 31-112-11/-ийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулж налуу зам төлөвлөсөн байна. **1-р давхарт:** Гонх, хонгил, шатны хонгил, үүдний талбай, өлгүүр, заал, тайз, музей, музейн фонд, ажлын өрөө, агуулах, хувцас солих өрөө, бэлтгэлийн өрөө, цахилгааны өрөө, дулааны өрөө, ариун цэврийн өрөөг, **2-р давхарт:** Хонгил, шатны хонгил, бүжгийн талбай, уншлагын танхим, ном олгох өрөө, номын сангийн өрөө, сургалтын өрөө, кино проекцийн өрөө, гэрэлтүүлгийн өрөөг тус тус төлөвлөсөн байна. **Барилгын үндсэн бүтээц нь:** **Суурь:** Цутгамал төмөр бетон баганан суурьтай, **Даацын үндсэн бүтээц нь:** Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй, **Гадна хана:** 360 мм-ийн блокон ханатай, 100 мм-ийн эрдэс хөвөн дулаалгатай, 120 мм-ийн тоосгон өрөгтэй, **Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилттай, **Дээвэр:** Хавтгай дээвэртэй байхаар тус тус төлөвлөжээ. **Гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлт, хүчин чадал:** **Гадна дулаан:** Барилгын гадна дулааны эх үүсвэрийг төлөвлөж буй халаалтын тогооны барилгаас төлөвлөж буй барилгад холбохоор төлөвлөсөн байна. <u>Дулаан механик:</u> Марк: GLSG-30-1400-700, 2 ширхэг, Чадал: 0.12 мВт, 70343 ккал/ц, **Гадна ариутгах татуурга:** Барилгаас гарах бохир усны шугамыг Ф 100 мм, Ф 150 мм-ийн голчтой, 30.7 м урттай, дулаалгатай, хуванцар хоолойгоор төлөвлөж буй 40 м^3 багтаамжтай цооногт холбохоор төлөвлөсөн байна. **Гадна цахилгаан:** Техникийн нөхцөлийн дагуу одоо байгаа 35/10 кВ-ын Арбулаг дэд станцын 10 кВ-ын гаргалгааны цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгуур № 10-ыг тулаастай салбарлалтын тулгуураар сольж, шинээр тавих эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан АС-50 маркийн 222.0 м урт кабель шугам сүүлийн тулгуур хүртэл татаж, хуурай салгуур тоноглон ААБлУ-3х185 мм^2 хөндлөн огтлолтой, 11.0 м урттай кабель шугамаар шинээр төлөвлөж буй 160 кВА чадалтай дэд станцыг тэжээхээр, КТПН-160 кВА дэд станцын 0.4 кВ талаас АВВБ-3х70+1х35 мм^2 хөндлөн огтлолтой, 64.0 м урттай кабель

3 –

	шугамаар төлөвлөж буй соёлын төвийн барилгын оролтын ерөнхий самбарыг тэжээхээр, тус барилгын оролтын ерөнхий самбараас АВБШв-4х10 мм^2 хөндлөн огтлолтой, 10.0 м урттай кабель шугамаар төлөвлөж буй халаалтын тогооны барилгын самбарыг тэжээхээр тус тус төлөвлөсөн байна. **Гадна холбоо, дохиолол:** Техникийн нөхцөлийн дагуу одоо байгаа сумын төвийн холбооны салбарын байрнаас 12 соге-ийн 220 м урттай шилэн кабель цэнэглэн авч, одоо байгаа болон шинээр төлөвлөж буй баганаар дамжуулан барилгад оруулж төгсгөлийн төхөөрөмжид холбохоор төлөвлөсөн байна. **Халаалтын тогооны барилга:** Барилга нь тэнхлэгээрээ 9.0 м х 6.0 м хэмжээтэй, зоорьгүй, 1 давхар. **1-р давхарт:** Халаалтын тогооны өрөө, галчын өрөө, цэвэр усны нөөцийн савны өрөөг тус тус төлөвлөсөн байна. **Барилгын үндсэн бүтээц нь:** **Суурь:** Цутгамал төмөр бетон баганан суурьтай, **Даацын үндсэн бүтээц нь:** Тоосгон өрөгт бүтээцтэй, **Гадна хана:** 510 мм-ийн тоосгон ханатай, **Хучилт:** Цутгамал төмөр бетон хучилттай, **Дээвэр:** Хавтгай дээвэртэй байхаар тус тус төлөвлөжээ.
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт:	**Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг холбогдох орон тооны бус экспертүүд шалгаад:** Экспертийн өгсөн зөвлөмжийн дагуу зураг төсөлд засвар хийсэн байна.
Эдийн засгийн үр ашиг, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, барилга байгууламжийн нийгмийн ач холбогдол зэргийг харгалзан гаргасан хөрөнгө оруулалтын үр ашгийн талаархи дүгнэлт.	"Соёлын төвийн барилга" баригдсанаар ажилчдын ажиллах орчин сайжирч, ажлын байр нэмэгдэх, урлаг соёлын арга хэмжээг стандартын шаардлага хангасан орчинд зохион байгуулах, иргэд чөлөөт цагаа зөв зохистой өнгөрөөх таатай нөхцөл бүрдэх юм.

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын "240 Соёлын төвийн барилга"-ын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоо:				
№	Барилга угсралтын ажлын			
Барилгын үндсэн хийц		Төсөвт өртөг /төг/	Барилгын талбай /м^2/	Нэгж өртөг /төг/
1	а/. Барилга угсралтын ажил /үндсэн/			
ББ	Соёлын төв: 27.0 м х 27.0 м, Давхрын тоо: Зоорьгүй, 2 давхар, Талбайн хэмжээ: 1,086.0 м^2	1,144,854,942.0	1,086.0	987,536.0
ХАС		36,067,141.0	1,086.0	116,020.0
ЦБУ		19,943,387.0	1,086.0	53,523.0
ДГ	Суурь: Цутгамал төмөр бетон баганан	57,034,731.0	1,086.0	31,467.0
ХД	Үндсэн хийц: Төмөр бетон арагт бүтээц, Гадна хана: 360 мм-ийн блокон хана, 100 мм-ийн эрдэс хөвөн дулаалга, 120 мм-ийн тоосгон өрөгтэй, Хучилт: Цутгамал төмөр бетон хучилттай, Дээвэр: Хавтгай дээвэртэй.	20,891,353.0	1,086.0	28,437.0
	Хэсгийн дүн	**1,278,791,554.0**	**1,086.0**	**1,177,524.5**
2	б/. Барилга угсралтын ажил /туслах/			
ББ	Тогооны барилгын ажил: Талбай 54.0 м^2, Зооргүй, Суурь: төмөр бетон багана, Үндсэн хийц: Төмөр бетон арагт бүтээц, Гадна хана:510 мм тоосго, Хучилт: Цутгамал төмөр бетон хучилт, Дээвэр: Хавтгай дээвэртэй.	61,534,910.0	54.0	1,139,535.4
	Хэсгийн дүн	**61,534,910.0**		
3	в/. Гадна инженерийн шугам сүлжээний ажил			
Инженерийн шугам сүлжээний үндсэн хийц		Төсөвт өртөг /төг/	Трассын урт /м/ хүчин чадал / Гкал,м^3 ширхэг/	Нэгж өртөг /төг/
3.1	Гадна дулааны шугамын ажил			
ГДГ	Гадна дулаан /м/: үл нэвтрэх цутгамал суваг ган хоолой Ф89 м	2,436,080.0	30.0	81,202.7
ДМ	Дулаан механик: бусад тоног төхөөрөмж, холбох хэрэгслийн угсралт	10,712,688.0	65.0	164,810.6
	Дүн	**13,148,768.0**		
3.2	Ариутгах татгуургын шугамын ажил			
АТ	Ариутгах татуургын шугам / м/ Хучитгэсэн хуванцар хоолой Ф150м	11,631,545.0	31.0	375,211.1
АТ	Бохир усны цооног /м^3/ цутгамал төмөр бетон	36,186,279.0	40.0	904,657.0
	Хэсгийн дүн	**47,817,824.0**		
3.3	Гадна цахилгааны шугамын ажил			

ГЦ	Гадна цахилгаан /м/ 0.4 кВ кабель шугам 3х185+3х16 мм^2	13,041,477.0	280.0	46,576.7
ГЦ	Дэд өртөө / ш/ Иж бүрэн / КТПН/ 160 кВА чадалтай	32,000,000.0	1.0	32,000,000.0
	Хэсгийн дүн	**45,041,477.0**		
3.4	Гадна холбооны шугамын ажил			
ГХ	Гадна холбоо	3,224,695.0	220.0	14,657.7
	Хэсгийн дүн	**3,224,695.0**		
4	г/. Гадна тохижилт			
ГТ	Явган зам, талбай /м^2/ Өнгөт хавтан хучилттай	13,220,355.0	509.0	25,973.2
ГТ	Явган зам, талбай /м^2/ 1 Бетон хучилттай /	10,660,420.0	250.0	42,641.7
	Хэсгийн дүн	**23,880,775.0**		
5	д/. Тоног, төхөөрөмж:			
ТТ	Халаалтын тогоо, ус нөөцлөх сав, насос	28,916,000.0	2.0	14,458,000.0
	Хэсгийн дүн	**28,916,000.0**		
6	е/. Зураг төслийн үнэ			
ЗТҮ	Зураг төслийн үнэ	39,809,600.0	1,086.0	36,657.1
ИГ	Инженер, геологи ,хайгуулын зардал	7,512,000.0	1,086.0	6,917.1
	Хэсгийн дүн	**1,549,677,603.0**		
Төсөвт өртгийн нэгдсэн товчоо:				
БУ	**Барилга угсралт / үндсэн /**	**1,278,791,554.0**		
БУ	**Барилга угсралт / туслах /**	**61,534,910.0**		
ГДГ	**Гадна дулаан хангамж**	**13,148,768.0**		
АТ	**Ариутгах татуурга /цооног.гбу/**	**47,817,824.0**		
ГЦ	**Гадна цахилгаан хангамж**	**13,041,477.0**		
ГХ	**Гадна холбоо**	**3,224,695.0**		
ГТ	**Гадна тохижилт, зам талбай**	**23,880,775.0**		
ТТ	**Тоног төхөөрөмж /28916000+30000/**	**60,916,000.0**		
ЗТҮ	**Зураг төсвийн үнэ**	**47,321,600.0**		
НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:			**1,549,677,603.0**	

Төсөв:	**Эксперт нь:** Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 4-р багийн нутаг дэвсгэрт баригдах "240 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын холболтын ажлын нийт төсөвт өртгийг **1,549,677,603.0** /нэг тэрбум таван зуун дөчин есөн сая зургаан зуун далан долоон мянга зургаан зуун гурван/ төгрөгөөр хянасан байна.

"Барилгын тухай" Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Тус зураг төсөл нь Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын 2019.03.14-ний өдрийн 38/06 дугаартай "Барилгын зураг төсөлд хяналт хийсэн тухай" дүгнэлтээр хянагдсан байна.

Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 4-р багийн нутаг дэвсгэрт баригдах "240 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын ажлын зураг төсөл, төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНбД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНбД 81-95-12/, Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Засаг даргын 2019.04.25-ны өдрийн 1/103 тоот албан бичгийг тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Ерөнхий дүгнэлт нь экспертүүдийн **14** хуудас магадлалын хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД
МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ Ц.АМАРСАНАА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ХАНГАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ
МАГАДЛАЛЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ЦОЛМОН-ОД

БАТЛАВ.
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ ..... Ц.АМАРСАНАА
201.9.. оны 05. сарын 21. өдөр

БАТЛАВ.
ЗАХИАЛАГЧ: "БАББ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ ..... Г.БААСАНЖАВ
201.9.. оны .... сарын .... өдөр

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ МАГАДЛАЛ ХИЙХ АЖЛЫН ГЭРЭЭ

Дугаар ...178/2019

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын "Барилгын тухай" хууль, “Иргэний хууль”-ийн 343 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийг үндэслэн зураг төсөлд магадлал хийх ажлын хүрээнд захиалагч, гүйцэтгэгчтэй холбогдон гарах үүрэг, хариуцлагыг хангахад энэхүү гэрээний зорилго оршино.

1.2. Нэг талаас Барилгын хөгжлийн төвийг төлөөлж Магадлалын асуудал хариуцсан нэгжийн дарга (цаашид “гүйцэтгэгч” гэх) нөгөө талаас Магадлал хийлгэх хүсэлт гаргасан Зураг төслийн байгууллага, аж ахуй нэгж, иргэн (цаашид **"захиалагч"** гэх) түүнийг төлөөлж Захирал ажилтай Г.Баасанжав нар дараахь зүйлийг харилцан тохирч энэхүү гэрээг байгуулав.

1.3. **Захиалагч** */Хөрөнгө оруулагч/* Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ

Зураг төслийн гүйцэтгэгч: "БАББ" ХХК

Обьектийн нэр: 240 хүний суудалтай соёлын төвийн барилгын ажлын зураг төсөл, төсөв

Зургийн шифр: БАББ 03/19

Обьектийн байрлал: Хөвсгөл аймаг, Арбулаг сум, 4-р баг

Зураг төслийн гэрээний үнийн дүн: 39,809,600 /төг/

/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар/

Магадлалын ажлын төлбөр: 1,809,530.0 төг /нэг сая найман зуун есөн мянга таван зуун гучин төгрөг/

/мөнгөн дүнг үсгээр, банкны төлбөрийн даалгаварт гэрээний дугаарыг бичсэн байна/

1.4. Зураг төсөлд гүйцэтгэгч нь Засгийн газрын 2012.12.01-ний өдрийн 151-р тогтоолыг үндэслэн магадлал хийгдсэн зураг төслийг баталгаажуулах хугацаа 7 хоног байгааг үндэслэн хуанлийн 21^1 хоногт багтаан магадлал хийх ажлыг хамтран зохион байгуулахаар харилцан тохиролцов. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх ажлыг зохион байгуулах, магадлал хийлгэх **ажлын хөлсийг** захиалагч нь тус газрын **Голомт банк 1175107789** тоот дансанд гэрээний хугацаанд багтаан шилжүүлсэн байна.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх

2.1. Барилгын хөгжлийн төвийн захирлын 2012 оны 43 тушаалаар батлагдсан ”Зураг төслийн баримт бичгийн бүрдлийг тодруулах хуудас”-ны загварын дагуу захиалагчаас тухайн ажилд шаардагдах материал, холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг гаргуулж авах;

2.2. Шаардлага хангаагүй зураг төслийн баримт бичгийн бүрдлийг захиалагчид албан тоотоор хариу өгөх;

Гурав. Гүйцэтгэгчийн үүрэг

3.1. “Барилгын тухай” хуулийн 25.2, 25.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн 5 дугаар зүйлийг үндэслэн магадлал хийлгэх ажлыг зохион байгуулах;

3.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар хүсэлтийн дагуу гэрээний хугацааг хоёр тал хамтран тохиролцсоны үндсэн дээр сунгах;

Дөрөв. Захиалагчийн эрх

4.1. Захиалагч орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дахин эксперт томилуулах санал оруулах;

4.2. Томилогдсон тухайн эксперт магадлалын ажлыг гүйцэтгэх боломжгүй бол ажлын 1 хоногийн дотор мэдэгдэж экспертийг дахин томилуулах;

4.3. Гэрээнд заагдсан хугацаанд ажлыг гүйцэтгэх боломжгүй тохиолдолд хугацааг сунгах, үндэслэлийг гаргах;

Тав. Захиалагчийн үүрэг

5.1. Гэрээний хавсралт бүхий баримт бичгийн үнэн зөвийг хариуцах;

5.2. Магадлалын ажилд шаардагдах хууль эрх зүйн баримт бичиг, материалыг тухай бүр цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж өгөх;

5.3. Магадлалын дүгнэлтээр гарсан зарчмын санал, зөрчлийг барилга байгууламжийн зураг төслийг хянан нягталж, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаанд багтаан залруулга, тодоруулга тайлбарыг хийж гүйцэтгэсэн байх;

5.4. Энэхүү гэрээний 1.4-д заасан хугацаатай уялдуулан орон тооны бус экспертийн гаргасан дүгнэлтийн дагуу залруулга /засвар/-ыг 10 хоногт багтаан хийж дуусган тус төвийн гэрээ хийсэн мэргэжилтэнд хүргүүлсэн байх;

Зургаа. Хүлээх хариуцлага

6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадаагүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ;

6.2. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх явцад ажлын шаардлагаар гэрээ сунгавал тухай бүр тэмдэглэл хөтөлж, гэрээний биелэлтийг дүгнэж сунгах эсэх асуудлыг шийдвэрлэж байна.

6.3. Зураг төсөл магадлалын ажил гүйцэтгэх явцад энэхүү гэрээний 5.4-т заасан хугацааг хэтрүүлсэн бол хугацаа хэтэрсэн хоног тутамд зураг төслийн магадлалын ажлын төлбөрийн дүнгийн 0.4 хувиар алдангийг тооцно.

6.4. Зураг төслийн баримт бичигт магадлал хийх хугацаанд байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртсөн нөхцөлд зайлшгүй нотлох баримтыг үндэслэн хоёр тал харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.5. Энэхүү гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь “Монгол хэл” байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Захиргаа, удирдлагын хэлтсийн
дарга ..... /Т.НЯМДАВАА/

Барилга байгууламжийн зураг төсөл
магадлалын хэлтсийн дарга
..... /Э.ХАНГАЛ/

Утас: 328097
Факс: 320338

Мэргэжилтэн
..... /М.МАРГАД-ЭРДЭНЭ/

Захиалагчийг төлөөлж:
Зураг төслийн байгууллага:

Захирал
..... /Г.БААСАНЖАВ/

Захиалагчийн утас:8801-0283
Гүйцэтгэгчийн утас:9982-7967

[1] *Хугацааг хуанлийн өдрөөр тооцно.*